

АГУУЛГА

1.Хараат бус аудиторын дүн.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙНТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗД	Засаг дарга
ЗГ	Засгийн газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Сөдлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас 7000 7734, Факс: (976-11) 32 01 54

И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

Холбоо барих: 011 305
Танай _____ -ны № _____ -г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Нийслэлийн Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Нийслэлийн Хот тохижилтын газар ОНӨААТҮГ нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нийслэлийн Хот тохижилтын газар ОНӨААТҮГ нь Цагаандаваа, Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгүүд, авто баазын уурын зуухыг шинэчлэх ажлын хүрээнд халаалтын 18 ширхэг бойлуурыг шинээр сольж хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Хот нийтийн аж ахуйн нэгдмэл байдлыг хангах, чиг үүргийн хамаарлыг оновчтой хуваарилах зорилтын хүрээнд Нийслэлийн Засаг Даргын 2023 оны А/1461 дүгээр захирамж, Хотын Ерөнхий менежерийн 2023 оны А/293 дугаар тушаалаар тус газрын зарим чиг үүргүүдийг дүүргүүдэд шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

НИЙСЛЭЛИЙН ХОТ
ТОХИЖИЛТЫН ГАЗАР
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Б.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

1425010131

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Мерийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	165,180,316.83	1,988,357,611.30
1.1.2	Дансны авлага	21,902,230.44	21,614,656.88
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	4,499,903.88	2,986,394.88
1.1.4	Бусад авлага	4,317,286.10	0.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	1,418,964,457.46	1,418,779,164.52
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	13,904,416.76	3,850,857.01
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,628,768,611.47	3,435,588,684.59
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	21,068,788,015.01	16,665,070,508.68
1.2.2	Биет бус хөрөнгө	545,768,410.11	540,219,980.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	21,614,556,425.12	17,205,290,488.68
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	23,243,325,036.59	20,640,879,173.27
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	27,343,270.00	500,000.00
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	31,396,084.11	123,655,882.17
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	58,739,354.11	124,155,882.17
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	0.00
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	58,739,354.11	124,155,882.17
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.1	Төрийн өмч	30,300,525,541.92	30,300,525,541.92
2.3.2	Хувийн өмч	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,085,132,228.50	1,085,132,228.50
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,614,953,013.74	2,460,565,758.54
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-9,816,025,101.68	-13,329,500,237.86
2.3.10	...	0.00	0.00
2.3.11	Эздийн өмчийн дүн	23,184,585,682.48	20,516,723,291.10
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	23,243,325,036.59	20,640,879,173.27

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	27,470,601,961.99	15,551,782,909.05
2	Борлуулалтын өртөг	0.00	0.00
3	Нийт ашиг (алдагдал)	27,470,601,961.99	15,551,782,909.05
4	Түрээсийн орлого	1,014,195,497.48	1,332,703,925.14
5	Хүүгийн орлого	3,716,009.22	9,044,754.00
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	210,869,791.04	631,889,846.59
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	32,380,544,570.73	17,537,033,665.28
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	2,650,000.00	38,340,000.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-150,505,752.69	-3,463,522,905.68
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-3,834,317,063.69	-3,513,475,136.18
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-3,834,317,063.69	-3,513,475,136.18
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-3,834,317,063.69	-3,513,475,136.18
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	-3,834,317,063.69	-3,513,475,136.18
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	31,207,908,027.83	19,355,144,108.36
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	31,154,746,787.53	19,268,651,601.33
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	53,161,240.30	86,492,507.03
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	32,257,063,580.70	17,293,804,283.99
1.2.1	Ажилагсад төлсөн	8,313,794,405.59	4,594,856,003.34
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,648,529,859.00	1,391,757,792.53
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	18,632,260,483.97	9,053,648,723.03
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	0.00	0.00
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	259,500,000.00	15,000,000.00

1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,118,372,304.92	1,676,196,794.65
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	284,606,527.22	562,344,970.44
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,049,155,552.87	2,061,339,824.37
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	51,259,366.05	28,227,205.10
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	51,259,366.05	28,227,205.10
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.00	0.00
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	712,045,354.59	266,389,735.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	712,045,354.59	266,389,735.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-660,785,988.54	-238,162,529.90
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	0.00	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-1,709,941,541.41	1,823,177,294.47
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,875,121,858.24	165,180,316.83
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	165,180,316.83	1,988,357,611.30

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	30,300,525,541.92	1,085,132,228.50	564,079,169.44	-5,981,708,037.99	25,968,028,901.87
3	Залруулсан үлдэгдэл	30,300,525,541.92	1,085,132,228.50	564,079,169.44	-5,981,708,037.99	25,968,028,901.87
5	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	1,050,873,844.30	0.00	1,050,873,844.30
6	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-3,834,317,063.69	-3,834,317,063.69
9	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	30,300,525,541.92	1,085,132,228.50	1,614,953,013.74	-9,816,025,101.68	23,184,585,682.48
11	Залруулсан үлдэгдэл	30,300,525,541.92	1,085,132,228.50	1,614,953,013.74	-9,816,025,101.68	23,184,585,682.48
12	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
13	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	661,472,744.80	0.00	661,472,744.80
14	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-3,513,475,136.18	-3,513,475,136.18
17	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	30,300,525,541.92	1,085,132,228.50	2,460,565,758.54	13,329,500,237.86	20,516,723,291.10

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/Төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	2024 он		Хэмнэлт хэтрэлт	
		Зорилт	Гүйцэтгэл	Зөрүү	Хувиар
1. Нийт орлого					
1.1. Үйл ажиллагааны орлого		8,360,870,169	17,976,889,641	9,616,019,472	115.0
1.1.1	Улаанбаатар хотын гол гудамж, зам талбайн цэвэрлэгээ	2,599,828,571	5,086,639,821	2,486,811,249	95.6
1.1.2	Төвлөрсөн хогийн цэгүүдэд хог дарж булах	4,464,285,714	6,639,412,155	2,175,126,440	48.7
1.1.3	Төвлөрсөн хогийн цэгт хог тээвэрлэж хүргэсэн машин техникийн дугуй, доод эд ангийг ариутгаж халдваргүйжүүлэх зардал, төвлөрсөн хогийн цэгүүдийн нэгдсэн камер, программ хангамжийн ашиглалт засвар үйлчилгээний ажил	235,714,286	235,714,286	-	-
1.1.4	Алтан-Өлгийн хүндэтгэлийн оршуулгын газрын арчлалт хамгаалалтын зардал	126,535,714	181,964,285	55,428,570	43.8
1.1.5	Золбин нохой муурын сэг, зэмийг устгах зардал	256,696,429	215,881,358	(40,815,070)	(15.9)
1.1.6	Үйл ажиллагааны бусад орлого	677,809,455	2,233,840,675	1,556,031,220	229.5
1.1.7	Хонхтой цэцэрлэгт хүрээлэнгийн усан оргилуурын ашиглалт, арчлалт, хамгаалалт, засвар үйлчилгээний ажил	-	267,857,143	267,857,143	
1.1.8	НЗД-ын захирамжаар эрх шилжиж ирсэн бүтээн байгуулалтын ажлууд	-	3,115,579,919	3,115,579,919	
Нийт орлогын дүн		8,360,870,169	17,976,889,641	9,616,019,472	115.0
2. Нийт зардал					
2.1. Үйл ажиллагааны зардал		10,905,080,092			(100.0)
2.1.1	Цалин	3,753,996,498	5,670,706,356	1,916,709,858	51.0
2.1.2	НДШимтгэл	544,329,492	750,927,052	206,597,559	37.9

2.1.3	Удирдах зөвлөлийн зардал /НДШ/- тэй	54,410,400	54,410,400	-	-
2.1.4	Ашиглалтын зардал	267,359,010	91,987,907	(175,371,103)	(65.5)
2.1.5	Түрээсийн зардал	24,000,000	10,616,290	(13,383,710)	(55.7)
2.1.6	Тос, масло, тосолгооны зардал	121,627,000	76,059,576	(45,567,424)	(37.4)
2.1.7	Машин техникийн сэлбэг хэрэгсэл	138,084,000	497,312,680	359,228,680	260.1
2.1.8	Хөдөлмөр хамгааллын зардал	40,976,200	91,093,262	50,117,062	122.3
2.1.9	Багаж хэрэгслийн зардал	46,120,000	17,829,010	(28,290,990)	(61.34)
2.1.10	Хангамжийн материал	177,733,000	2,878,453,967	2,700,720,967	1,519.5
2.1.11	Дулааны зардал /хийн түлш/	243,997,600	231,335,521	(12,662,079)	(5.1)
2.1.12	Цэвэрлэгээний материал	18,025,645	255,642,097	237,616,451	1,318.2
2.1.13	ТЭМ-Ногоон байгууламж	-	-	-	-
2.1.14	Зар сургалчилгааны зардал	25,522,727	-	(25,522,727)	(100.0)
2.1.15	Албан томилолтын зардал	-	-	-	-
2.1.16	Шуудан холбооны зардал	21,660,000	17,009,364	(4,650,636)	(21.4)
2.1.17	Бичиг хэргийн зардал	17,333,900	14,032,790	(3,301,110)	(19.0)
2.1.18	Шатахуун	2,302,188,120	1,478,795,929	(823,392,191)	(35.7)
2.1.19	Нийгмийн арга хэмжээний зардал болон албан хаагчдад урамшуулал	291,575,000	516,936,148	225,361,148	77.2
2.1.20	Сургалтын зардал	35,600,000	38,340,000	2,740,000	7.70
2.1.21	Үндсэн хөрөнгийн элэгдэл	2,497,348,407	2,100,237,485	(397,110,922)	(15.9)
2.1.22	Онцгой үеийн зардал	-	-	-	-
2.1.23	Бусад зардал	283,193,092	4,168,478,906	3,885,285,815	1,371.9
2.1.24	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	-	2,079,813,632	2,079,813,632	-
Нийт зардлын дүн		10,905,080,092	21,040,018,371	10,134,938,279	92.9
3	Татварын өмнөх ашиг	(2,544,209,923)	(3,063,128,730)	(518,918,808)	20.4

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙНТОДРУУЛГА

3.1 ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-нь "Нийслэл хотын иргэдийн ая тухтай, эрүүл орчинд амьдрах, ажиллах нөхцлийг хангаж, хотын өнгө төрхийг орчин үеийн өндөр түвшинд хүргэх" зорилготой төвлөрсөн хогийн цэгүүд, нийтийн эзэмшлийн гудамжны зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан үйл ажиллагаа явуулдаг байна. Тайлант онд 5 зорилтын хүрээнд 12 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласан байна.

3.2 ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

"Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ нь Нийслэлийн эрх зүйн байдлын тухай, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хог хаягдлын тухай Байгаль орчныг хамгаалах тухай, Зөрчлийн тухай, Хөдөлмөрийн тухай хуулиуд болон бусад хууль тогтоомж, НИТХ-ын тогтоол, ЗД-ын захирамж, мөрийн хөтөлбөр, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн тушаал, албан даалгавар, ТУЗ-өөс гаргасан шийдвэр, холбогдох заавар журмуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд тус газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Нийслэлийн ИТХ-ын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн "Тариф шинэчлэн батлах тухай" 5 дугаар тогтоолын 1 дэх заалт "...хог хаягдлыг цэвэрлэх зардлын тарифыг 50 төгрөгөөр..." гэснийг "...хог хаягдлыг цэвэрлэх зардлын тарифыг 70 төгрөгөөр..." гэж өөрчлөлт оруулсныг 2024 оны 03 дугаар сарын 1-ээс мөрдсөн байна.
- Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1461 дугаар захирамж, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2023 оны А/293 дугаар тушаалаар чиг үүрэг шилжүүлэх ажлын хэсэг байгуулагдаж 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс тус газрын зарим чиг үүргийг дүүргүүдэд шилжүүлсэн байна.

Тус газрын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын 2022 оны А/14 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,602.45 мянган төгрөгөөр буюу 11.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	165,180.32	1,988,357.61	1,823,177.29
Авлага	30,719.42	24,601.05	(6,118.37)
Бараа материал	1,418,964.46	1,418,779.16	(185.29)
Урьдчилж төлсөн зардал	13,904.42	3,850.86	(10,053.56)
Үндсэн хөрөнгө	21,614,556.43	17,205,290.49	(4,409,265.94)
Нийт хөрөнгө	23,243,325.04	20,640,879.17	(2,602,445.86)
Өр төлбөр	58,739.35	124,155.88	65,416.53
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	23,184,585.68	20,516,723.29	(2,667,862.39)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	23,243,325.04	20,640,879.17	(2,602,445.86)

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан дараах данс байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 1,823,177.29 мянган төгрөгөөр өссөн нь "Халтиргаа гулгаа арилгах зориулалтын бодис худалдан авах" тендерт Санлиахими ХХК шалгарсан боловч хугацаандаа хүлээлгэн өгөөгүйгээс санхүүжилт олгогдоогүй, хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт оны сүүлд орж ирсэнтэй холбоотой;

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 4,409,265.9 мянган төгрөгөөр буурсан нь НӨХГ-ын 2024 оны А/118 дугаар тушаалаар 4 ширхэг тээврийн хэрэгсэл, А/484

тушаалаар 2 ширхэг барилга, А/253 дугаар тушаалаар 178 ширхэг машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталж данснаас хассантай холбоотой;

Мөн Нийслэлийн ЗД-ын 2024 оны А/757 дугаар захирамжаар 92 ширхэг тээврийн хэрэгсэл, НӨХГ-ын А/128 тушаалаар 28 ширхэг тээврийн хэрэгсэл, Нийслэлийн ЗД-ын 2024 оны А/439 дугаар захирамжаар 2 ширхэг тээврийн хэрэгсэл, Нийслэлийн ЗД-ын А/979 захирамжаар 60 ширхэг тээврийн хэрэгсэл, НӨХГ-ын даргын А/258 дугаар тушаалаар 68 ширхэг тоног төхөөрөмж балансаас балансад шилжүүлсэнтэй холбоотой;

Өр төлбөр данс 65,416.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны НӨАТ-ын өр үүссэнтэй тус тус холбоотой байна.

Цэвэр хөрөнгө, өмчийн дүн өмнөх оноос 2,667,862.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны алдагдал нөлөөлсөн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хот тохижилтын газар ОНӨААТҮГ зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Нийслэлийн ЗД-ын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/755 дугаар захирамжаар Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 8,360,870.2 мянган төгрөг, нийт зардлыг 10,905,080.1 мянган төгрөг, 2,544,209.9 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 3,438,160.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Зорилтот түвшний орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	2024 он		Хэмнэлт хэтрэлт	
		Зорилт	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.1	Үйл ажиллагааны орлого	8,360,870.1	17,976,889.6	9,616,019.4	115
1.1.1	Улаанбаатар хотын гол гудамж, зам талбайн цэвэрлэгээ	2,599,828.5	5,086,639.8	2,486,811.2	96
1.1.2	Төвлөрсөн хогийн цэгүүдэд хог дарж булах	4,464,285.7	6,639,412.1	2,175,126.4	49
1.1.3	Төвлөрсөн хогийн цэгт хог тээвэрлэж хүргэсэн машин техникийн дугуй, доод эд ангийг ариутгаж халдваргүйжүүлэх зардал, төвлөрсөн хогийн цэгүүдийн нэгдсэн камер, программ хангамжийн ашиглалт засвар үйлчилгээний ажил	235,714.2	235,714.2	-	100
1.1.4	Алтан-Өлгийн хүндэтгэлийн оршуулгын газрын арчлалт хамгаалалтын зардал	126,535.7	181,964.2	55,428.5	44
1.1.5	Золбин нохой муурын сэг, зэмийг устгах зардал	256,696.4	215,881.3	(40,815.0)	15
1.1.6	Үйл ажиллагааны бусад орлого	677,809.4	2,233,840.6	1,556,031.2	229

1.1.7	Хонхтой цэцэрлэгт хүрээлэнгийн усан оргилуурын ашиглалт, арчлалт, хамгаалалт, засвар үйлчилгээний ажил	-	267,857.1	267,857.1	
1.1.8	НЗД-ын захирамжаар эрх шилжиж ирсэн бүтээн байгуулалтын ажлууд	-	3,115,579.9	3,115,579.9	

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 17,976,889.64 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 21,040,018.37 мянган төгрөгийн зардал гарган, 3,063,128.73 мянган төгрөгийн татварын өмнөх алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 17,976,889.64 мянган төгрөг болж төлөвлөснөөс 9,616,019.47 мянган төгрөг буюу 115.0 хувиар давсан нь НИТХ-ын 2024 оны "Нийслэлийн 2024 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 105 дугаар тогтоолыг үндэслэн санхүүжилтийн орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл

/мянган төгрөг/

№	Үйл ажиллагааны зардал	Үзүүлэлтүүд		Хэмнэлт хэтрэлт	
		Зорилт	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин	3,753,996.4	5,670,706.3	1,916,709.8	51
2	НДШимтгэл	544,329.4	750,927.0	206,597.5	38
3	Удирдах зөвлөлийн зардал	54,410.4	54,410.4	-	100
4	Ашиглалтын зардал	267,359.0	91,987.9	(175,371.1)	34
5	Түрээсийн зардал	24,000.0	10,616.2	(13,383.7)	44
6	Тос, масло, тосолгооны зардал	121,627.0	76,059.5	(45,567.4)	37
7	Машин техникийн сэлбэг хэрэгсэл	138,084.0	497,312.6	359,228.6	60
8	Хөдөлмөр хамгааллын зардал	40,976.2	91,093.2	50,117.0	122
9	Багаж хэрэгслийн зардал	46,120.0	17,829.0	(28,290.9)	61
10	Хангамжийн материал	177,733.0	2,878,453.9	2,700,720.9	1519
11	Дулааны зардал /хийн түлш/	243,997.6	231,335.5	(12,662.0)	5
12	Цэвэрлэгээний материал	18,025.6	255,642.0	237,616.4	1318
13	Зар сурталчилгааны зардал	25,522.7		(25,522.7)	
14	Шуудан холбооны зардал	21,660.0	17,009.3	(4,650.6)	21

15	Бичиг хэргийн зардал	17,333.9	14,032.7	(3,301.1)	19
16	Шатахуун	2,302,188.1	1,478,795.9	(823,392.1)	35
17	Нийгмийн арга хэмжээний зардал болон албан хаагчдад урамшуулал	291,575.0	516,936.1	225,361.1	77
18	Сургалтын зардал	35,600.0	38,340.0	2,740.0	8
19	Үндсэн хөрөнгийн элэгдэл	2,497,348.4	2,100,237.4	(397,110.9)	15
20	Бусад зардал	283,193.0	4,168,478.9	3,885,285.8	1371
21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	-	2,079,813.6	2,079,813.6	
Нийт зардлын дүн		10,905,080.0	21,040,018.3	10,134,938.2	93

Нийт зардлын гүйцэтгэл 21,040,018.37 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 10,134,938.28 мянган төгрөг буюу 193.0 хувиар давсан гүйцэтгэлтэй байна. Орлого нэмэгдсэнтэй холбоотойгоор нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээ, төвлөрсөн хогийн цэгүүдийн хүнд нөхцөлд ажиллаж буй ажилтан албан хаагчдын сарын үндсэн цалинг нэмэгдүүлсэн нь зардал өсөх гол шалтгаан болсон байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 6 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 3,108,500.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг/алдагдал 3,063,100.0 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 518,900.0 мянган төгрөгөөр илүү байгаа нь орлого нэмэгдсэнтэй холбоотойгоор нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээ, төвлөрсөн хогийн цэгүүдийн хүнд нөхцөлд ажиллаж буй ажилтан албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэн нь нөлөөлжээ. ТӨБЗГ-т тайлант онд ногдол ашиг төвлөрүүлээгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Санхүү бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн ахлах аудитор Н.Энхмэнд, аудитор Ж.Мөнхтуяа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер С.Гантөгс, хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр, дэд дарга Ч.Болд нар тус тус хэрэгжүүлсэн.

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Нийслэл дэх Төрийн газарт 2025 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн 01/490 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн тайланг, суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 32,257,063.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 483,855.9 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор бодис цацах тусгай зориулалтын 37 тээврийн хэрэгслүүдэд GPS суурилуулснаар авто машинуудын туулсан зам, түлшний зарцуулалт, цаг ашиглалтыг хянах боломжтой болж, ажлын цаг ашиглалт сайжирч хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэх, түлшний зардал буурсан үр дүн гарсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 6 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ нь тайлант онд шилэн дансны цахим хуудаст нийт 157 мэдээлэл байршуулахаас 17,731,358.9 мянган төгрөгийн мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд:

ТБОНӨХБАҮХАТХ, Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг түүвэрлэн үзэхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1.Тайлант онд албан хэрэгцээнд 143,854.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, бусад этгээдээс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.2-д "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ", 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.13-д "Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант онд худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж байх, цахим дэлгүүрээс худалдан авалт хийх зөвлөмж өгөв.

2. "Халтиргаа гулгаа арилгах бодис" худалдан авах тендэрт шалгарсан "Санлиахими" ХХК-тай 309,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, гэрээнд заасан хугацаанд бодис нийлүүлэгдсэн боловч техникийн нөхцөлд тусгагдсан шалгуур үзүүлэлт хангаагүй шалтгаанаар төлбөрийг шилжүүлээгүй, гэрээг дүгнээгүй байна.

Энэ нь Худалдан авах гэрээний 5-д "нийлүүлэгч нь зориулалтын бодисыг 2024 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн дотор нийлүүлнэ" гэсэн заалт, санхүүгийн тайлагналын хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний эрх, үүргийг хангуулж ажилллаагүй, гэрээг дүгнээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/225 дугаар захирамжаар "Гараж хайс хашлага буулгаж чөлөөлсөн газарт нөхөн сэргээлт хийх, явган зам, ногоон байгууламжийн барилгын ажил, зөвлөх үйлчилгээ"-г худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар тус байгууллагад эрхийг шилжүүлсэн байна. Тайлант онд туслан гүйцэтгэгч 28 компанитай гэрээ байгуулж, 90.0 хувийн гүйцэтгэлтэйгээр он дамжсан байна. Ажил гүйцэтгэсэн компаниуд үлдэгдэл санхүүжилтээ аваагүй, ГЕН-д заасан баталгаат хугацаанд барьцаа хөрөнгө суутган авч чөлөөлөх гэрээний заалт хэрэгжээгүй байна.

Энэ нь ГЕН 6.8-д "Барьцаа хөрөнгө 5 хувь байна. Хугацаа 1 жил байх бөгөөд тус хугацаа дууссанаар ашиглагч байгууллагын тодорхойлолтыг үндэслэн барьцаа хөрөнгийг чөлөөлж гүйцэтгэгчид олгоно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Туслан гүйцэтгэгч компаниудтай байгуулсан гэрээг дүгнэж ажиллах зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 3,839,051.9 мянган төгрөгийн 4 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах 4 зөвлөмж өгснийг үнэлэхэд бүрэн хэрэгжүүлсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 34,096.1 мянган төгрөгийн 5 зөвлөмж, 115,515.5 мянган төгрөгийн 5 албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	5	115,515.5	5	115,515.5	100
Зөвлөмж	5	34,096.1	5	34,096.1	100
Нийт дүн	10	149,611.60	10	149,611.60	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нийслэлийн Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 225,369.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 5,927.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 63,662.1 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 155,780.1 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлээ.

Нийт 225,369.6 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшинд хүрээгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.1 Төлбөрийн акт

1. Нийт зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Гадаад томилолтоор ажиллах ажилтан, алба хаагчдын томилолт цуцлагдсантай холбоотой онгоцны тийзны 5,927.4 мянган төгрөгийн алдангийг тухайн "Эйр маркет" ХХК нислэгийн компанид суутгуулж үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагаас төлсөн 5,927.4 мянган төгрөгийн алдангийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Нийт зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: "Ганга ар үр" ХХК-иар 29,480.0 мянган төгрөгийн ажил гүйцэтгүүлэхдээ шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ын 2-д "Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 100 сая" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдлын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-2: Ахмад настны тухай хуулийг үндэслэн тус газарт ажиллаж байгаа 50 наснаас дээш 49 ажилтанд хүндэтгэл үзүүлэн, 14,553.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгож, төсвийг үргүй зарцуулсан байна.

Энэ нь Ахмад настны тухай хуулийн 3.1-д "Энэ хуулийн үйлчлэлд 60, түүнээс дээш настай эрэгтэй, 55, түүнээс дээш настай эмэгтэй Монгол Улсын иргэн хамаарна", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай зарцуулаагүй, холбогдох хуулийг хэрэгжүүлээгүй зөрчлийг зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт-3: Хангамжийн материалын дансанд 19,629.1 мянган төгрөгийн дэрсэн шүүр, хөвөнтэй бээлий, ариун цэврийн цаас их хэмжээний үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Их хэмжээгээр бараа материал нөөцөлсөн зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

1. Нийт зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Тайлант онд ТУЗ-ийн хурал бүрэн хийгдээгүй байхад урамшууллыг сар бүр тооцон 18,000.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь НИТХ-ын 2014 оны "Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн ажиллах журмын 3.2-д "Удирдах зөвлөлийн ээлжит хурлыг улиралд 1-ээс доошгүй удаа заавал хуралдуулах бөгөөд хуралд нийт гишүүдийнх нь олонхи оролцоноор хүчин төгөлдөр болно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: "Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн ажиллах журам"-д заасны дагуу ТУЗ-ийн хурлыг улиралд 1-ээс доошгүй удаа хуралдуулаж байх.

Илрүүлэлт-2: Цагаан давааны төвлөрсөн хогын цэгийн булдозерийн 10,263.0 мянган төгрөгийн засварыг Парцланд ХХК-иар гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгүүлсэн байна. Тус гэрээг дүгнэж акт үйлдээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдлын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гэрээг дүгнэж, анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих дотоод хяналтыг сайжруулах.

Илрүүлэлт-3: Ашиглах боломжгүй болсон 127,517.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн асуудлыг холбогдох газарт хандан шийдвэрлүүлээгүйгээс дээрх хөрөнгийн элэгдлийн зардал тайлант оны ашигт ажиллагаанд нөлөөлсөн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.2-д "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны

байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТУЗ-ийн хурал тайлант онд бүрэн хийгдээгүй байхад урамшууллыг сар бүр тооцон олгосон байна.	1	18,000.0					1	18,000.0
Гадаад томилолтоор ажиллах ажилтан, алба хаагчдын томилолт цуцлагдсантай холбоотой онгоцны тийзны алдангийг тухайн "Air market holiday" LLC нислэгийн компанид суутгуулж үр ашиггүй зардал гаргасан байна.	1	5,927.4	1	5,927.4				
Тус газрын хэлтэс албадад ажиллаж байгаа 50 наснаас дээш 49-н ажилтанд ахмад настны тухай хуулиар хүндэтгэл үзүүлэн нэг удаагийн тэтгэмж олгосон байна.	1	14,553.0			1	14,553.0		
Цагаан давааны төвлөрсөн хогын цэгийн булдозерийн засврыг Парцланд ХХК-иар ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан байна. Тус гэрээг дүгнэж акт үйлдээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.	1	10,263.0					1	10,263.0
"Ганга ар үр" ХХК-иар 29,480.0 мянган төгрөгийн ажил гүйцэтгүүлэхдээ шууд гэрээ байгуулсан байна.	1	29,480.0			1	29,480.0		
Хангамжийн материалын дансанд дэрсэн шүүр, хөвөнтэй бээлий, ариун цэврийн цаас их хэмжээний үлдэгдэлтэй байна.	1	19,629.1			1	19,629.1		
Ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн асуудлыг холбогдох газарт хандан шийдвэрлүүлээгүйгээс тус хөрөнгийн элэгдлийн зардлаар тайлант оны ашигт ажиллагаанд нөлөөлсөн байна.	1	127,517.1					1	127,517.1

22 | НТАГ-2025/080/НА-СТА-ОНӨҮГ

Дүн	1	225,369.6	1	5,927.4	3	63,662.1	3	155,780.1
------------	----------	------------------	----------	----------------	----------	-----------------	----------	------------------

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд албан хэрэгцээнд зориулж тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.	1	143,854.4					1	143,854.4
"Халтиргаа гулгаа арилгах бодис" худалдан авах тендэрийг тайлант онд зарлаж гүйцэтгэгч "Санлиа хими" ХХК-ийг шалгаруулж гэрээ байгуулсан байна. Гэрээний хугацаанд бодис нийлүүлэгдсэн боловч техникийн нөхцөлийн шалгуур үзүүлэлт хангаагүй шалтгаанаар төлбөрийг шилжүүлээгүй, гэрээг дүгнээгүй байна.	1	309,000.0			1	309,000.0		
Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/225 дугаар захирамжаар "Гараж хайс хашлага буулгаж чөлөөлсөн газар дээрх нөхөн сэргээлт хийх, явган зам, ногоон байгууламжийн барилгын ажил, зөвлөх үйлчилгээ"-г худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар тус байгуулагад эрх шилжүүлсэн байна. Тус онд туслан гүйцэтгэгч 28 компанитай гэрээ байгуулж одоогийн байдлаар нийт 90 хувийн гүйцэтгэлтэйгээр он дамжсан байна. Ажил гүйцэтгэсэн компаниуд үлдэгдэл санхүүжилтээ аваагүй, ГЕН-д заасан баталгаат хугацаанд барьцаа хөрөнгө суутган авч чөлөөлөх гэрээний заалт зөрчигдсөн байна.	1	611,922.3					1	611,922.3
Дүн	3	1,064,776.7			1	309,000.0	2	755,776.7

23 | НТАГ-2025/080/НА-СТА-ОНӨҮГ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр Дугаар 286/АУТ0187 Улаанбаатар хот
НТАГ-2025/080/НА-СТА-ОНӨУГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Ганга ар үр" ХХК-иар 29,480,000.00 (хорин есөн сая дөрвөн зуун наян мянган) төгрөгийн ажил гүйцэтгүүлэхдээ шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ын 2-д "Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 100 сая" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11."хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шууд гэрээ байгуулсан зөрчлийг зогсоон, биелэлтийг 2025 оны 08 дугаар сарын 29-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ-ын захирал Б.Мөнхцэцэг, нягтлан бодогч М.Оюунсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

Ж.МӨНХТУЯА
Н.ЭНХМЭНД

ХЯНАСАН

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

С.ГАНТӨГС

1117115633
УХАА/12 9077278

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 4 давхар

1425040207

24 | НТАГ-2025/080/НА-СТА-ОНӨУГ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр Дугаар 287/АУТ0187 Улаанбаатар хот
НТАГ-2025/080/НА-СТА-ОНӨУГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус газрын хэлтэс албадад ажиллаж байгаа 50 наснаас дээш 49-н ажилтанд ахмад настны тухай хуулиар хүндэтгэл үзүүлэн 14,553,000.00 (арван дөрвөн сая таван зуун тавин гурван) мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосон байна

Энэ нь Ахмад настны тухай хуулийн 3.1."Энэ хуулийн үйлчлэлд 60, түүнээс дээш настай эрэгтэй, 55, түүнээс дээш настай эмэгтэй Монгол Улсын иргэн хамаарна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11."хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Тус байгууллагад ажиллаж байгаа 50-н наснаас дээш алба хаагчдад нэг удаагийн тэтгэмж олгосон зөрчлийг зогсоон, биелэлтийг 2025 оны 08 дугаар сарын 29-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ-ын захирал Б.Мөнхцэцэг, нягтлан бодогч М.Оюунсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

Ж.МӨНХТУЯА
Н.ЭНХМЭНД

ХЯНАСАН

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

С.ГАНТӨГС

1117115633
УХАА/12 9077278

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 4 давхар

1425040209

25 | НТАГ-2025/080/НА-СТА-ОНӨУГ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 14 өдөр Дугаар 289/А0270187 Улаанбаатар хот
НТАГ - 2025/080/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хангамжийн материалын дансанд 19,629,100.00 (арван есөн сая зургаан зуун хорин есөн мянган нэг зуун) төгрөгийн дэрсэн шүүр, хөвөнтэй бээлий, ариун цэврийн цаас их хэмжээний үлдэгдэлтэй байна

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11."хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Материалын үлдэгдлийг их хэмжээгээр нөөцөлсөн зөрчлийг зогсоон, биелэлтийг 2025 оны 08 дугаар сарын 29-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ-ын захирал Б.Мөнхцэцэг, нягтлан бодогч М.Оюунсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР Ж.МӨНХТУЯА
АХЛАХ АУДИТОР Н.ЭНХМЭНД
ХЯНАСАН:
САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР С.ГАНТӨГС

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1425040212



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 14 өдөр Дугаар 289/А0270187 Улаанбаатар хот
НТАГ - 2025/080/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Халтиргаа гулгаа арилгах бодис" худалдан авах тендэрт шалгарсан "Санлиахими" ХХК-тай 309,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан байна. Гэрээний хугацаанд бодис нийлүүлэгдсэн боловч техникийн нөхцөлийн шалгуур үзүүлэлт хангаагүй шалтгаанаар төлбөрийг шилжүүлээгүй, гэрээг дүгнээгүй байна.

Энэ Худалдан авах гэрээний 5-д "нийлүүлэгч нь зориулалтын бодисыг 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн дотор нийлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11."хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Гэрээний эрх, үүргийн биелэлтийг хуулийн дагуу шийдвэрлэж, биелэлтийг 2025 оны 08 дугаар сарын 29-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ-ын захирал Б.Мөнхцэцэг, нягтлан бодогч М.Оюунсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР Ж.МӨНХТУЯА
АХЛАХ АУДИТОР Н.ЭНХМЭНД
ХЯНАСАН:
САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР С.ГАНТӨГС

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1425040214



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 03 дугаар сарын 14

№ 86/А0270187

Улаанбаатар хот

НТАГ - 2025/080/НА-СТА-ОНӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гадаад томилолтоор ажиллах ажилтан, алба хаагчдын томилолт цуцлагдсантай холбоотой онгоцны тийзны 5,927,400.00 (таван сая есөн зуун хорин долоон мянган дөрвөн зуун) төгрөгийн алдангийг тухайн "Эйр маркет" ХХК нислэгийн компанид суутгуулж үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 6.4.1."Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө". Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8."Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн." заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Нийслэлийн Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын томилолт цуцлагдсантай холбоотой онгоцны тийзны 5,927,400.00 (таван сая есөн зуун хорин долоон мянган дөрвөн зуун) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банк дахь НТАГ хүү орлогын 100200000908 тоот дансанд төвлөрүүлэх.

2.Актын биелэлтийг 2025 оны 08 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын захирал Б.Мөнхцэцэг, нягтлан бодогч М.Оюунсүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН1:

АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

САНХҮҮ НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

ХЯНАСАН:



Ж.МӨНХТУЯА

Н.ЭНХМЭНД

С.ГАНТӨГС

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

143-380091